



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

### Эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2004 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 163 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр, тус төв үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг тус тус тохиолдуулан салбарын ажилтан, ажилчдын ажил үйлсийг сурталчлах, хөдөлмөр, бүтээлийг тодруулан үнэлэх, олон нийтэд мэдээлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулах үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг холбогдох зардлын зүйл ангиас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (Б.Очир)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга (Л.Оюунчимэг)-д даалгасугай.


ЗАХИРАЛ



Ч.БАТ-ЭРДЭНЭ



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын  
2016 оны 08 дугаар сарын 05...-ны  
өдрийн 1/104 дугаар тушаалын хавсралт



Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр, тус төв үүсэн байгуулагдсаны  
20 жилийн ойн хүрээнд зохион байгуулах ажлын хөтөлбөр

№	Арга хэмжээ	Хариуцах эзэн
1	Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Ажлын хэсэг
2	Тэргүүний албан хаагчийн хөдөлмөр алдрыг тэмдэглэх	ЗААА
3	Албан хаагчдыг шагнаж урамшуулах	ЗААА
4	Баярын хурал, хүндэтгэлийн арга хэмжээ, уулзалт, өдөрлөг, уралдаан тэмцээн	Ажлын хэсэг Спорт хамтлаг
5	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр салбар, байгууллагын ололт амжилтыг сурталчлах	Б.Нямсүрэн Н.Балжир